МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2017.02.08 № 05/1522
танай 2017.01.27-ны № 01/143 -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХЖАРГАЛ
ТАНАА

М.Хүүбаян -д
Бүтцийн өөрчлөлтийн хийж нэр бүхий хүмүүсийг албан тушаалд томилох
2017-02-14

Хувийн ашиг сонирхлын
урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай

Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн албаны халдварт, шимэгчтэх өвчин, тархвар судлалын асуудал хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Цогвоогийн Гэрэл, Мал эмнэлгийн албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Мягмарын Хүүбаян, Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Батмөнхийн Цэрэнханд, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Отгонбаатарын Ганцэцэг нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Цаашид нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар ирүүлж буй албан бичигт томилогдохоор нэр дэвшиж буй албан тушаалыг тодорхой тусгаж холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу ирүүлэхэд анхаарч ажиллана уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР Х.ХАШБААТАР